

2025 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй “100-Эрүүл мэнд” төслийн хүрээнд “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтны аппликэйшн хөгжүүлэх” ажил

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Эрүүл мэндийн тогтолцоог хамгийн үр ашигтай, чанартай зохион байгуулах гол арга зам бол “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлж, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлснээр хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгодоо хүрнэ” гэдгийг зөвлөсөн. Мөн бүхи нийтийн эрүүл мэндийн хамралтыг бодитой болгох, тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн зорилтыг хангахад гол хөдөлгөгч хүч нь “анхан шатны тусламж, үйлчилгээ” хэмээн тодорхойлсон байна.

Энэхүү төсөл арга хэмжээ нь Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд учирч байгаа тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэхэд олон нийтийг татан оролцуулсан бусад улс орны туршлага болон НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр олон нийтийн эрүүл мэндийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай аппликэйшныг нэн тэргүүнд хөгжлүүлж нэвтрүүлэх зорилготой юм. Тус ажил 2025 оны 11 сарын 25-аас эхлэсэн.